



БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ КАТАЛОГ



SINCE 2010

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

"Тайван Зул" ХХК нь

2010 онд хүнсний бүтээгдэхүүний импортын чиглэлээр байгуулагдан, хөрш орнуудаас хүнсний бүтээгдэхүүн импортлон, нийлүүлж байв.

2013 онд Хүнсний бүтээгдэхүүний савлагааны үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Савлах үйлдвэр нь импортын пүнтүүз, долоогоно жимсэн чихэр, ногоон цай гэх мэт бүтээгдэхүүнүүдийн савлагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан..

2016 онд Болсон чангаамал будааны үйлдвэрийг нэвтрүүлж Эх орондоо анхны болсон будааны үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Тус үйлдвэрийн зорилго нь импортын болсон будааг орлож, амт чанарыг сайжруулахад оршиж байсан юм.

2019 онд Пүнтүүзний үйлдвэрлэл эхлүүлж мөн Монголдоо анхдагч импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэв. Амтат төмсний болон эрдэнэ шишийн гэсэн 2 төрлийн пүнтүүзийг үйлдвэрлэн нийлүүлж байна.

2023 онд Нунтаг хүнсний бүтээгдэхүүний савлагаа болон үйлдвэрлэл эхлэв.

2024 онд Үйлдвэрийн өргөтгөл хийгдэж үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж шинэ бүтээгдэхүүнүүдийн боловсруулалт хийгдэв.



Бид "ЗӨВХӨН ЭРҮҮЛ ХҮНСИЙГ" гэсэн уриатайгаар Эх орондоо үйлдвэрлэсэн, чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ нийлүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажилдаг.

Үүсгэн байгуулагч Б.Даваа

ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА

Манай үйлдвэр 1000 мкв бүхий 10 хэсгээс бүрдсэн, хагас автомат үйлдвэр юм. Тоног төхөөрөмжийн хувьд Хятад улсын GUANGZHOU TIANJIN хотуудын тоног төхөөрөмжийн үйлдвэрт өөрсдийн чанар стандартад нийцүүлэн захиалгаар хийлгэсэн хагас автомат хүнсний зориулалтын sus304, sus201 зэвэрдэггүй ган тоноглол бүхий төхөөрөмжөөр бүх шатандаа тоноглогдсон.

Манай үйлдвэр будаа боловсруулах хэсэг, будааны савлагааны хэсэг, пүнтүүз зуурах хэсэг, пүнтүүз боловсруулах хэсэг, пүнтүүз хөлдөөх хэсэг, пүнтүүз хатаах хэсэг, савлагааны хэсэг, агуулах, оффис, аж ахуйн хэсэг зэрэг нийт 10-н хэсгээс бүрдэнэ.



БОЛСОН ШАР БУДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ

"БОЛСОН ШАР БУДАА" -ны үйлдвэрлэлд бид ОХУ-аас дээд сортын шар будааны үрийг түүхий эд болгон авч, өөрсдийн технологиор боловсруулж үйлдвэрлэн бэлэн бүтээгдэхүүн болгон нийлүүлдэг. Болсон будааны үйлдвэр ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг сахиж mns4632:1998 чанарын стандартад нийцүүлэн гэнийн өөрчлөлтгүй, 100% байгалийн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.



/Боловсруулах процессын зураг/

Түүхий эдээ ОХУ-ын Барнаул хотоос ГОСТ 22983-88 чанарын шаардлага хангасан дээд сортын шар будааг гэрээт компаниудаас импортлон авдаг.

БОЛСОН ШАР БУДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ

"БОЛСОН ШАР БУДАА" -ны үйлдвэр 2024 онд өргөтгөл хийгдэж хүчин чадлаа нэмэгдүүлэн сард 100тн буюу 600,000 ширхэг бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэх чадалтай болсон.



ШАР БУДАА нь Дэлхий дээр маш эрт үед бий болсон үр тарианы нэг гэж үздэг ч гений өөрчлөлтөд ороогүй хүнсний нэг юм.

Байнгын эмчилгээнд байдаг хүмүүст шар будааны зутан идэхийг зөвлөдөг. Яагаад гэвэл бие дэх хаванг маш сайн хөөх мөн ясны сийрэгжилт, арьсны өнгө сэргээх ач тустай.

Шар будааг байнга хэрэглэж хэвшсэнээр бие бялдар болоод бие мах бодийг чангаруулж, булчингийн үйл ажиллагааг сайжруулдаг. Мөн гэдэсний түгжрэл, ходоодны болон нарийн бүдүүн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнд сайнаар нөлөөлдөг Шар будаа нь уураг болон биед хэрэгтэй олон ашигтай агууламж, амин хүчлүүд өөрт агуулж байдаг. Үүнээс гадна хөхүүл эхэд шар будааны зутан шөл болон болсон шар будаан дээр халуун сүү хийн идвэл эхийн сүүний гарцыг нэмэгдүүлдэг ач тустай.

ПҮНТҮҮЗНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

VERMICELLI буюу амтат төмсний пүнтүүзийг 2019 онд Монголдоо анх удаа үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд одоогоор Монголд үйлдвэрлэж байгаа цорын ганц амтат төмсний пүнтүүзний үйлдвэр юм. Бид түүхий эдээ Оросын Холбооны Улс болон Беларус улсаас албан ёсны гэрээтэйгээр импортолж Солонгос технологиор үйлдвэрлэн дээд сортын амтат төмсний пүнтүүзийг үйлдвэрлэн "МАШИСО" гэсэн нэртэйгээр нийлүүлдэг.



Мөн манай үйлдвэр эрдэнэ шишийн пүнтүүзний үйлдвэрлэлд ОХУ, Беларус Хятад, Тайланд, Вьетнам зэрэг орнуудаас түүхийн эдээ импортлон, өөрсдийн технологиор Монгол улсын чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн "ТУНГАЛАГ" гэсэн нэртэйгээр нийлүүлдэг.

ПҮНТҮҮЗНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Манай үйлдвэр пүнтүүзийг ямар нэгэн хүнсний нэмэлт ашиглахгүйгээр цэвэр дээд сортын цардуулаар үйлдвэрлэдэг.

Бид одоогоор 3-н нэр төрлийн 10-н янзын савлагаатайгаар нийт өдөрт 3000кг буюу 6000ш бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэх хүчин чадалтай.



/Боловсруулах процессын зураг/

НУНТАГ БҮТЭЭГДЭХҮҮН

2023 онд бид нунтаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл савлагааг эхлүүлж болсон шар будааг тээрэмдэн нунтаг будаа болгон худалдаанд гаргасан. Мөн амтат төмсний крахмал болон эрдэнэ шишийн крахмалыг ОХУ болон Беларус улсын гэрээт үйлдвэрүүдээс импортолж, савлан нийлүүлж байна.



Нунтаг шар будаа нь цай, хоолонд өвөрмөц амт оруулдаг ба пакеттай сүүтэй цайны гол орц болдог. Бид савлан худалдаанд гаргахаас гадна сүүтэй цай үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэн дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг.


ШАР БУДААНЫ БОЛОВСРУУЛСАН ХИВЭГ

Шар будааг боловсруулах явцад шар будааны хивэг гардаг ба энэхүү хивэг нь тэжээллэг чанар өндөртэй учир мал аж ахуйд малын нэмэлт тэжээл, бордоо болгон ашгилдаг.



САВЛАГАА

Өөрсдийн үйлдвэрлэж буй болон импортын бараа бүтээгдэхүүнийг хагас автомат, хүнсний зориулалтын sus 304, 201 зэвэрдэггүй ган тоноглол бүхий савлагааны машинаар эрүүл ахуйн шаардлага ханган савалдаг.





БОЛСОН ШАР БУДАА

Савалгаа:
150гр /Боодолд 40ш/
Орц найрлага: Шар будаа



**БОЛСОН ШАР
БУДАА**

Савалгаа:
200гр /Боодолд 60ш/
Орц найрлага: Шар будаа




**НУНТАГ БОЛСОН
БУДАА**

Савалгаа:
150гр /Боодолд 40ш/



**МАШИСО ПҮНТҮҮЗ
/АМТАТ ТӨМСНИЙ/**

Савалгаа:
500гр /Хайрцагт 20ш/
1000гр /Хайрцагт 10ш/
Орц найрлага: 100% Амтат
төмсний цардуул



ТУНГАЛАГ ПҮНТҮҮЗ

Дунд зэрэглэлийн пүнтүүз
Савалгаа:
450гр /Шуудайнд 50ш/
900гр /Шуудайнд 25ш/

Орц найрлага:
Амтат төмсний цардуул,
эрдэнэ шиш болон
тапиока цардуул



ТУНГАЛАГ ПҮНТҮҮЗ

Бага зэрэглэлийн пүнтүүз
Савалгаа:
400гр /Шуудайнд 60ш/
300гр /Шуудайнд 80ш/

Орц найрлага:
Амтат төмсний цардуул
/бага хувиар/,
эрдэнэ шиш болон
тапиока цардуул



НАВЧИТ НОГООН ЦАЙ

Төрөл: Шахмал
Савалгаа: 1200гр
Хайрцагт: 20ш



НАВЧИТ НОГООН ЦАЙ

Төрөл: Шахмал
Савалгаа: 700гр
Хайрцагт: 30ш



НАВЧИТ НОГООН ЦАЙ

Төрөл: Пакеттай
Савалгаа: 90гр
Хайрцагт: 50ш

КАТАЛОГ**ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН****ДОЛООГОНО ЖИМСЭН
ЧИХЭР**

Савалгаа:
1000гр /Хайрцагт 10ш/

**ДОЛООГОНО ЖИМСЭН
ЧИХЭР**

Савалгаа:
150гр /Хайрцагт 50ш/

**ДОЛООГОНО ЖИМСЭН
ЧИХЭР**

Савалгаа: Урт хуйлсан
270гр /Хайрцагт 30ш/

**БЭЛЭН ГОЙМОН
/АЯГТАЙ, КИМЧИТЭЙ/**

Савалгаа:
118 гр /Хайрцагт 12ш/

**БЭЛЭН ГОЙМОН
/ЧАНАДАГ, КИМЧИТЭЙ/**

Савалгаа:
110 гр /Хайрцагт 20ш/

**ДОТНО СЭТГЭЛ
БЭЛЭН ГОЙМОН**

Савалгаа:
88гр /Хайрцагт 50ш/

КАТАЛОГ**ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН****ЖАН ӨТГӨН ЦУУ**

Савалгаа: /САВТАЙ/
910гр /Хайрцагт 12ш/

**КРАХМАЛ
/ЭРДЭНЭ ШИШИЙН/**

Савалгаа:
2000гр

**КРАХМАЛ
/АМТАТ ТӨМСНИЙ/**

Савалгаа:
200гр

**ТҮРГЭН ИСГЭГЧ
ДХ**

САВЛАГАА: 12ГР Х 200Ш
500ГР Х 20Ш, 5КГ Х 2Ш

ISO 9001:2015 QUALITY MANAGEMENT
SYSTEM CERTIFICATE
ISO 22000:2018 FOOD SAFETY MANAGEMENT
SYSTEM CERTIFICATE

ТҮГЭЭЛТ

"TAZULA TRADE" ххк үйлдвэрлэсэн болон импортын бараа бүтээгдэхүүнийг түгээлтийг хариуцан зах, бөөний худалдааны төвүүд, сүлжээ дэлгүүрүүдийн агуулах болон жижиг дэлгүүрүүд гэсэн хувиараар түгээдэг.



Бид түгээлтийн байршил, захиалгын хэмжээнээс хамааран тохирох тээврийн хэрэгсэлийг түгээлтэнд гаргадаг ба хотын төвийн байршлуудад төв замын тусгай зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгсэлээр бүтээгдэхүүнээ түгээдэг.

ЗӨВХӨН
ЭРҮҮЛ
ХҮНСИЙГ...



9999-8249
9999-2249



WWW.TAIVANZUL.MN



ТАЙВАН Зул ХХК



Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
7-р хороо, хувьсгалчдын Б-4 гудамж, 215б тоот

WHAT3WORDS
SHADAR.SHAGNANA.GYALBAA